

“ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК” ХХК
#13 давхар, Твин тауэр-1, Сөүлийн гудамж 10/1
2-р хороо, СБД, 14251 Улаанбаатар
Утас: 77090077 И-мэйл: info@icapital.mn
Вебсайт: www.icapital.mn

1021.06.08 № А-21/33

Үнэт цаасны анхдагч арилжааны
хуваарилалтын төлөвлөгөө хүргүүлэх
тухай

“Инвескор Капитал ҮЦК” ХХК (РД: 6317839) нь “Инвескор ББСБ” ХК-ийн Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан нийтэд санал болгон арилжаалахаар өрийн хэрэгсэл гаргах ажиллагаанд андеррайтерийн үйлчилгээ үзүүлж байгаа билээ. “Инвескор ББСБ” ХК-ийн нийтэд санал болгон гаргаж арилжаалах 20,000,000,000 /хорин тэрбум/ төгрөг хүртэлх үнийн дүн бүхий Инвескор Бонд өрийн хэрэгслийг Санхүүгийн Зохицуулах Хорооны 2021 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 200 дугаар тоот тогтоол, Монголын Хөрөнгийн Биржийн Гүйцэтгэх захирлын 2021 оны 02-р сарын 03-ны өдрийн А/10 тоот тушаал, 2021 оны 05-р сарын 03-ны өдрийн А/38 тоот тушаалаар тус тус бүртгэсэн болно.

Тус өрийн хэрэгслийн хөтөлбөрийн Нэгдүгээр транч болох нийт 8,000,000,000 төгрөг хүртэлх үнийн дүн бүхий, 13 хувийн хүүтэй Инвескор Бонд өрийн хэрэгслийн анхдагч зах зээлийн арилжааг Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан 2021 оны 06-р сарын 14-ний өдөр эхлүүлж, ажлын 3 өдөр буюу 2021 оны 06-р сарын 16-ны өдрийг дуусах хүртэл хугацаанд өглөөний 10 цаг 00 минутаас 16 цаг 00 минутын хооронд Биржийн “Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам”-ын 10 дугаар зүйлд заасны дагуу тогтоосон үнийн аргаар явуулах хүсэлтэй байгаа бөгөөд үнэт цаасны анхдагч арилжааны хуваарилалтын төлөвлөгөөг дараах байдлаар хүргүүлж байгааг хүлээн авна уу. Үүнд:

1. Нийт 8,000,000,000 төгрөг хүртэлх үнийн дүн бүхий 80,000 ширхэг хүртэлх үнэт цаасны 50 хүртэх хувьтай тэнцэх 40,000 ширхэг буюу 4,000,000,000 төгрөг хүртэлх үнийн дүнтэй үнэт цаасыг Биржийн “Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам”-ын 3.4 дэх хэсэгт заасны дагуу стратегийн хөрөнгө оруулагчдад хуваарилах бөгөөд стратегийн хөрөнгө оруулагчдын жагсаалт, хөрөнгө оруулагч тус бүрд хуваарилагдах үнэт цаасны тоо ширхэг болон бусад шаардлагатай мэдээллийг анхдагч зах зээлийн арилжаа эхлэх үед болон арилжааны явцад Биржид хүргүүлэх болно.

2. Нийт 8,000,000,000 төгрөг хүртэлх үнийн дүн бүхий 80,000 ширхэг хүртэлх үнэт цааснаас стратегийн хөрөнгө оруулагчдад хуваарилагдаагүй үлдсэн үнэт цаасыг олон нийтэд нээлттэй /жижиглэнгийн хөрөнгө оруулагчдад/ хуваарилна. Мөн олон нийтэд нээлттэй хуваарилах үнэт цаасны худалдан авах захиалга нь 10,000,000 төгрөг буюу 100 ширхэг болон түүнээс бага дүнтэй байх тохиолдолд бүрэн биелэх нөхцөлтэй байна. Олон нийтийн худалдан авах захиалгын тоо ширхэг нь дээр дурдсан хэмжээнээс илүү гарсан тохиолдолд нэгж хөрөнгө оруулагчийн 100 ширхэг үнэт цааснаас давсан үнэт цаасны захиалгыг хувь тэнцүүлэх аргыг ашиглан жижиглэнгийн хөрөнгө оруулагчдад үнэт цаасны хуваарилалт хийнэ.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  Ф.УЯНГАХИШИГ

